

Ноён хутагтын “Итгэмжлэх мэтийн итгэл үгүй”
шүлгийн монгол төвөд эхүүдийн судалгаа

Дашнямын МӨНХ-ОТГОН*
Монгол Улс, Улаанбаатар,
ШУА-ийн Хэл зохиолын
хүрээлэнгийн Сурвалж бичиг,
төвөд судлалын салбар

Received: Aug 23, 2024

Revised: Sep 07, 2024

Accepted: Nov 08, 2024

Хураангуй: Говийн ноён хутагт Данзанравжаагийн зохиол бүтээлийг гадаад дотоодын эрдэмтэн судлаачид сонирхон судалж эхэлсээр багагүй хугацаа өнгөрч байна. Хутагтын монгол хэлээрх шүлэг зохиолын судалгаа нь харьцангуй өргөн дэлгэр хөгжсөн гэхэд болох бөгөөд харин төвөд хэлээрх бүтээлийн судалгаа нь төдийлөн ахицтай биш байгаа юм. Үүнтэй уялдаад монгол төвөд хоёр хэлээр байдаг хэд хэдэн зохиолын судалгаа нь ч туйлын ховор хомс гэж хэлж болно. Тиймээс энэхүү өгүүлэлд Ноён хутагтын монгол төвөд хоёр хэлээр байдаг зохиолуудын судалгааны ерөнхий тойм хийгээд түүний дээр саяхан шинээр олдсон нэгэн зохиолын монгол төвөд эх бичгүүд, тэдгээрийн харьцаа, ялгаа зөрөө зэргийг жишээлэн өгүүлэхийг зорилоо.

Түлхүүр үг: Ноён хутагт, монгол төвөд эх бичиг, хуулбар, хувилбар

A Study of Mongolian and Tibetan Texts of the Poem “No Trust Such as
Entrusting” Written by Noyon Khutugtu

MUNKH-OTGON Dashnyam
The Sector of the Textology and Tibetan Studies,
Institute of Language and Literature,
Mongolian Academy of Sciences,
Ulaanbaatar, Mongolia

Abstract: Not few years have been passing hence the foreign as well as domestic scholars and researchers are being studied and interested in the literary works written by Gobi's King Reincarnate Danzanravjaa. One can say that the study of poems and other literary works written in the Mongolian language by the

* © Д.Мөнх-Отгон 2024

Email: munkhotgond@mas.ac.mn

Reincarnate had developed in a comparatively wide range. But the study of works written in the Tibetan language is not so progressive as would like. In this connection, it is worth mentioning that the study of several literary works that exist in the Mongolian and Tibetan languages is extremely rare and scarce. Therefore, in this article, we tried to narrate the general study review of works by King Reincarnate that do exist in the Mongolian and Tibetan language versions, as well as the Mongolian and Tibetan texts of one work that has been found recently, and their correlations, distinctions, discrepancies and others based on concrete examples.

Key words: *Noyon Khutugtu, Mongolian and Tibetan original texts, copies and versions.*

1. Удиртгал

XIX зууны нэрт соён гэгээрүүлэгч, буддын гүн ухаантан, яруу найрагч, зохиолч, говийн ноён хутагтын тавдугаар дүр Данзанравжаа нь монгол төвөд хоёр хэлийг төгс сайн эзэмшсэний зэрэгцээ шүлэг зохиолоо ч тэрхүү хоёр хэлээр тэгш чадмаг туурвин бичдэг хосгүй их авьяас билигтэн. Чингэхлээр түүний зохиол бүтээлийг дан монгол хэлээр, дан төвөд хэлээр, монгол төвөд хос хэлээр буй хэмээн үзэж болох юм. Энэ тухай ч манай ахмад эрдэмтэд дурдсаар ирсэн гэдгийг тэмдэглэх хэрэгтэй. Хутагтын монгол хэлээрх зохиолуудын судалгаа харьцангуй өргөн дэлгэр өрнөсөөр байгаа. Харин төвөд хэлээрх бүтээлийн судалгаа нь нэлээд явцуу хүрээнд буюу цөөн тооны эрдэмтэн судлаачид нэг хоёрын зэрэг ном зохиол туурвижээ. Мөн монгол төвөд хоёр хэлээр буй шүлэг зохиолын харьцуулсан судалгаа ч туйлын ховор хомс байгаа ба энэ төрлийн судалгаа шинжилгээний ажил чухал шаардлагатай тул эзнээ хүлээсээр байна. Ноён хутагтын монгол төвөд хоёр хэлээр буй шүлэг зохиолуудын талаар академич Ц.Дамдинсүрэн “Тавдугаар ноён хутагтын зохиосон “Цаасан шувуу”-аас гадна төвөд монгол хоёр хэлээр бичсэн олон шүлэг байдаг боловч одоо их төлөв үрэгдэж олдохгүй болжээ.” (1959: 445) гэж бичиж байсан юм.

Төвөдч эрдэмтэн Ч.Алтангэрэл “Чухамдаа монгол төвөд хэлний алин дээр урьд зохиосон нь үл мэдэгдэх, Равжаа өөрөө хөрвүүлсэн буюу бусад хүн хөрвүүлсэн нь мэдэгдэхгүй хэдхэн зохиол байна. Үүнд “Үлэмжийн чанар”, “Тэргэл сар”, “Ичиг ичиг”, “Цаасан шувуу”, “Цогт лам” гэх мэт зохиол буй.” (1968: 3-4) хэмээн номынхоо удиртгал хэсэгт бичив.

Бас эрдэмтэн Д.Ёндон “Түүний зарим зохиол төвөд монгол хоёр хэлээр тааралдах нь бий. Жишээлбэл: “Үлэмжийн чанар”, “Тэргэл сар”, “Ичиг ичиг”, “Цаасан шувуу”, “Цогт лам”, “Хоосон дууны бархирлага” зэргийг чухам анх ямар хэлээр (төвөдөөр үү, монголоор уу) зохиосныг шийдэхэд хэцүү байна” (МУЗТ, 1977: 590) гэж бичсэн удаатай.

Эдгээрийн дээр өмнө дурдагдаж байгаагүй төвөд монгол хоёр хэлээр буй шүлэг ч сүүл үес нэмэгдэх төлөвтэй. Эрдэмтэн Д.Цагааны эмхэтгэн хэвлэсэн “Д.Равжаа. Яруу найргийн цоморлиг” номын дотор “Хоосон дууны бархирлага”

хэмээх шүлэг бий. Бүр сүүл үес эрдэмтэн Р.Отгонбаатар “Равжаа хэмээгдэх ламын номлол сургаал оршвой” (rabjiy-a kemegdekü blam-a-yin nomlal suryalı orusibai:) гэх гарчигтай нэгэн монгол гар бичмэлд буй хоёр шүлгийн талаар хэвлүүлэв (2019: 28-37). Тэрхүү бичмэлд дээрх шүлгийн өмнө хэвлэгдсэнээс өөр нэгэн монгол шинэ сонин хувилбар эх хамт байжээ. Энэ шүлгийн төвөд эх нь Ч.Алтангэрэлийн “Монгол зохиолчдын төвөдөөр бичсэн бүтээл” доторх 23 дахь шүлэг (1968: 121-122) мөн юм. Өөр нэгэн төвөд гар бичмэлээс үүний ганц нэгэн үгийн зөрөөтэй төвөд эх байгаа талаар миний бие тусгайд нь жижиг өгүүлэл бичсэн удаатай (Мөнх-Отгон, 2022: 114-121). Чингээд энэхүү шүлгийн хоёр төвөд эх, хоёр монгол эх олдоод байгаа боловч эрдэмтэн Д.Ёндоны дурдсанчлан чухам анх ямар хэлээр зохиосныг судалж тогтоох шаардлагатай. Өөр нэгэн шүлэг нь “Хорин нэгэн хэрэгтэй хэмээх сургаал үг оршвой” гэх нэрээр эрдэмтэн Ч.Алтангэрэлийн төвөд хэлнээс орчуулсан шүлгийн уламжлалт монгол эх байсныг тодруулж өмнө дурдагдсан хоёр хэлээр буй шүлэг зохиолуудын дээр ахин нэгийг нэмэрлэв.

2. Судалгааны арга, хэрэглэгдэхүүн

Энэхүү өгүүлэлд Монгол Улсын Үндэсний номын сангийн төвөд номын сан хөмрөгт М0060721-004 дансны дугаартай хадгалагдаж буй төвөд гар бичмэл судар, Тавдугаар ноён хутагтын төвөд хэлээр туурвисан зохиолын эмхэтгэл (2023), эрдэмтэн Д.Цагааны эмхэтгэн хэвлүүлсэн “Д.Равжаа. Яруу найргийн цоморлиг” (1992), эрдэмтэн Д.Ёндоны орчуулгыг Л.Хүрэлбаатарын эмхэтгэн хэвлүүлсэн “Алтан хүрдэн” (1992) зэрэг ном бүтээлийг голлох судалгааны эх хэрэглэгдэхүүнээр ашигласан болно.

3. Судалгааны хэсэг

Эрдэмтэн Д.Цагаан Ноён хутагтын монгол хэлээр туурвисан шүлэг зохиолуудын судалгааг нарийвчлан хийж 1962, 1992 онд тус тус эмхэтгэн хэвлүүлснийг бид бүгд мэднэ. Тэдгээрийн дотор “Итгэмжлэх мэтийн итгэл үгүй” гэсэн нэртэй нэгэн шүлэг бий (Цагаан, 1962: 323; 1992: 182). Тэрхүү шүлгийг эрдэмтэн Д.Цагаан “Тавдугаар ноён хутагт зүүдээр зохиосон нь гэсэн гар бичмэлийн 14-өөс бичив” хэмээн тодорхой тэмдэглэсэн юм. Цухас тэмдэглэхэд “Тавдугаар ноён хутагт зүүдээр зохиосон нь” гэсэн гар бичмэл нь ховор сонин шүлгүүдийг багтаасан эмхэтгэл байсныг бид тэр эмхэтгэлд багтсан шүлгүүдээс мэдэж болох байна. “Итгэмжлэх мэтийн итгэл үгүй” хэмээх шүлгийн тухайд онцлон өгүүлэх хэрэгцээ шаардлага гарсан нь энэхүү шүлгийн төвөд эх бидний гарт олдоод байна.

Манай улсын Үндэсний номын сангийн төвөд номын сан хөмрөгт М0060721 дансны дугаар бүхий өврийн судрын хэмжээтэй “**dge slong gi phyir bcos sogs**” хэмээн гарчигласан 37 янз бүрийн зохиолыг багтаасан нэгэн бичмэл

эмхэтгэл¹²⁵ бий. Тэрхүү бичмэлийн дөрөв дэх ном нь Ноён хутагт Данзанравжаагийн зохиол юм. Түүн дотор Ноён хутагтын хоёр шүлэг бий. Эхний шүлэг нь “Ичиг ичиг” шүлгийн төвөд эх, удаах нь “Итгэмжлэх мэтийн итгэл үгүй” хэмээх монгол шүлгийн эхээс зарим хэсэг нь давуу олон мөртэй хийгээд яг тохирох хэдэн шад буй.

Үүнээс гадна төвөдч эрдэмтэн Л.Хүрэлбаатарын эмхэтгэн хэвлүүлсэн “Алтан хүрдэн” цоморлогийн дотор Ноён хутагтын цөөн хэдэн төвөд хэлээр бичсэн шүлгийн орчуулга багтсан ба бидний хэлэлцэн буй шүлэгтэй тохирох шүлгийг эрдэмтэн Д.Ёндон орчуулан хэвлүүлжээ.

Мөн тун саяхан хэвлэгдэн гарсан “Тавдугаар ноён хутагтын төвөд хэлээр туурвисан зохиолын эмхэтгэл” дотор бас хоёрын зэрэг үүнтэй төсөөтэй бичмэл хуулбар байна. Тэдгээрийн нэг нь уг хэвлэгдсэн бүтээлийн 725-880 дугаар тал дахь “mgur sna tshogs zhes bya ba bzhugs so” буюу монголчилбол “Элдэв дуу эгшиг хэмээгдэх оршвой” гэсэн гарчигтай 78 хуудас бүхий бичмэл эмхэтгэлийн дотор 6 дугаар хуудасны өвөр болон ар талд бий. Удаах нь мөн хэвлэлийн 996-1072 дугаар тал дахь “rab rgyas ming can gyis mdzad pa zhes bya ba bzhugs so” буюу монголчилбол “Равжаа нэрт бээр зохиосон хэмээгдэх оршвой” гэсэн гарчигтай 39 хуудастай бичмэл эмхэтгэлийн дотор 34 дүгээр хуудасны нүүр талын хагаст байгаа болно.

Хүснэгт. Төвөд монгол эхүүдийг харгуулсан хүснэгт

1	2	3	4
Д.Цагаан /монгол эх/	M0060721-004 /төвөд эх/	Алтан хүрдэн /Д.Ёндоны орчуулга/ <i>Багш дор мөргөмүй</i>	Төвөд зохиолын эмхэтгэл
	sems la phan na nyan bshad bzang,		
	zhi zhing 'dul na thos rtags yin,		
	nyon mongs chung na bsgom brtags yin,		
	gnas lugs thon na rnal 'byor yin,		
Итгэмжлэх мэтийн итгэл үгүй	yid ches lta bu'i skyabs skyabs 'gro med,		

¹²⁵ <https://library.bdrc.io/show/bdr:MW1NLM2803>

Сүжиг мэтийн эрдэм үгүй	dad pa lta bu'i yon tan med,		
Хичээл мэтийн түргэн мөр үгүй	brtson 'grus lta bu'i myur lam med,		
Чогчид мэтийн буянгүй	tshogs mchod lta bu'i bsod nams med,		
	bla ma'i rnal 'byor lta bu'i mang ngag med,		
Нойроос сэрэх цаггүй бол мунхрах шинж	gnyid las sang dus med na rmongs pa'i rtags,	Нойроос сэрэх цаггүй бол мунхрахын шинж	gnyid nas slong dus med na marig brtags,
Үйлийг цээрлэх цаггүй бол цалгайрахын шинж	las la 'dzem dus med na 'chal ba'i rtags,	Үйлээс зайлах цаггүй бол зовохын шинж	las las 'dzem dus med na ga.yengs kyi brtags,
Зальхайг тэвчих цаггүй бол хождохын шинж	le lo spangs dus med na phyis ma'i rtags,	Залхуурлаа тэвчих цаггүй бол нялхын шинж	ngal kyi spangs dus med na 'phyis kyi brtags,
Өөрийн сэтгэлийг номхотгохын цаггүй бол номгүйн шинж	rang sems 'dul dus med na 'chos pa'i rtags,	Сэтгэлээ номхотгох цаггүй бол номгүйн шинж	rang sems 'dul dus med na 'chos med 'gyur,
			brtags steng sa la bzhag 'og sa 'bros kyi,
			bde 'gror bzhag na ngan song la 'bros pa,
			snyigs ma'i dus kyi ngang tshul 'di mthong khyod,
Сонссоноо мартвал оюуны мунхаг	thos pa brjed na blo yis rmongs,	Бусдаас сонссоноо тас	

		мартвал оюуны мунхрал	
Бурханы номыг эс үйлдвэл шуламсын үйл	lha chos mi byed bdud kyi las,	Бурханы номыг эс үйлдвэл шулмын үйл	
	sgrib sbyangs snying po rdor sems bsgom bzlas bshags sdom yin,		
	byin rlabs snying po rtsa ba'i bla ma'i rnal 'byor yin,		
	tshogs bsags snying po phyi nang gsang ba'i mandal yin,		
	dngos grub snying po rang rig ji bzhin rtogs pa yin,		
	sngon 'gro'i snying po'o,		
	sems kyi steng du ma 'byor na,		
	nyams len thams cad gol bar 'gro,		
	zhes pa'ang gdod ma'i rang grol gyis bris,	Үүнийг Равжаа бээр өгүүлэв.	

Энэхүү хүснэгтийн дотор уг шүлгийн яг тохирч байгаа хэсгүүдийг тодруулан тэмдэглэсэн учир эдгээр монгол төвөд эхүүдийн зөрөө ялгаатай байдал илэрхий харагдана. Улсын номын санд буй төвөд бичмэл нь монгол эхэд байхгүй олон мөрүүдийг эхэндээ болон төгсгөлдөө агуулсан нь бүр ч тодорхой байна.

“Алтан хүрдэн” цоморлог доторх эхийг эрдэмтэн Д.Ёндон “Багш дор мөргөмүй” нэрээр орчуулсан бөгөөд төвөд эх нь өнөө хэр судлаачдын гарт хүрээгүй байсан билээ. Харин түүний ашигласан эхэд **“Залхуурлаа тэвчих цаггүй бол нялхын шинж”** гэх мөрд байгаа **“нялх”** (byis) хэмээх үг нь төвөд эхүүд болон Д.Цагааны хэвлэсэн монгол эхээс харахад **“Зальхайг тэвчих цаггүй бол хождохын шинж”** гэж буй нь төвөд эхүүдийн **“’phyis”** гэх үг нь зөв болохыг харуулна.

Мөн Улсын номын сан дахь төвөд эхэд бусад монгол болон төвөд эхүүдэд байхгүй “*bla ma'i rnal 'byor lta bu'i mang ngag med*” буюу монголоор үгчлэн орчуулбал “**Багшийн иог мэтийн увдис үгүй**” гэх мөр бий. Уг төвөд бичмэл судрын эхний дөрвөн мөр нь Ноён хутагтын өөр төвөд хэлээрх эмхэтгэлүүдэд тохиолдож байна. Тухайлбал Ч.Алтангэрэлийн эмхэтгэн хэвлүүлсэн “Монгол зохиолчдын төвөдөөр бичсэн бүтээл” номын “Үзвээс зохистой” хэмээх бичмэлийн 106 дахь төвөд шүлгийн сүүлийн мөрүүдтэй таарч буй. Харин сүүлийн найман мөр нь “Үзвээс зохистой” бичмэл дэвтэрт болон Ноён хутагтын төвөд хэлээрх зохиолын эмхэтгэл дотор байхгүй. Эдгээр хэдэн мөр нь эрдэмтэн Д.Ёндоны хэвлэхээр бэлтгэсэн боловч хараахан амжаагүй байсан Ноён хутагтын хэдэн төвөд зохиолын эхийн галиг дотор тааралдав.

Улсын номын сан дахь төвөд бичмэлийн төгсгөлийн үгэнд “*zhes pa'ang gdod ma'i rang grol gyis bris*” гэж буйг орчуулбал “хэмээснийг ч Угаас өөрөө гэтэлсэн бээр бичив” гэсэн утгатай бөгөөд төвөдөөр Додмарандол, монголоор Угаас өөрөө гэтэлсэн гэх нэр нь Ноён хутагтын олон нэр алдрын нэгэн мөн юм. Энэхүү нэрээ монгол төвөд хэлээр туурвисан олон шүлгийнхээ төгсгөлд бичсэн байдаг. Мөн Д.Ёндоны орчуулсан шүлгийн төгсгөлд “Үүнийг Равжаа бээр өгүүлэв” гэсэн байгаа нь түүнд олдсон эхэд “*di'ang rab rgyas kyis smras*” хэмээн төвөдөөр бичсэн эх олдсон бололтой. Дээр дурдсан хоёр төвөд хуулбар нь төгсгөлийн үг мэдээ үгүй боловч Ноён хутагтын зохиол бүтээлийн эмхэтгэл дотор буй юм. Ямар боловч уг зохиолын төвөд эхийн төгсгөлийн мэдээ зэрэг нь Данзанравжаагийн зохиол мөн болохыг давхар баталж байна.

Ерөөс Ноён хутагтын монгол болон төвөд хэлээр үлдэж хоцорсон шүлэг зохиол нь ард түмний дунд асар их түгэхийн зэрэгцээгээр хуулагдан тархаж байхдаа илүү дутуутай болсон явдал нь түүний зохиол бүтээлийг нэг бүрээр нь нарийвчлан зааглаж судалж шинжлэхэд нэлээд төвөгтэйг тэмдэглэх хэрэгтэй. Иймэрхүү байдал нь бидний энд өгүүлэн буй “Итгэмжлэх мэтийн итгэл үгүй” хэмээх шүлгийн олон эхээс бүр ч тодорхой харагдав. Зөвхөн энэ шүлгээр хязгаарлагдахгүй Хутагтын бүхий л шүлэг зохиол, бичмэлүүд нь дээрх мэт төвөгтэй байдал тохиолдсоор билээ. Учир иймд Ноён хутагтын зохиол бүтээлийн бичмэл эмхэтгэл, товхимол зэргийг гарт олдохын хэрээр харьцуулан судалж шинжлэх хэрэгцээ шаардлага бийг судлаачид анхаарах нь чухал гэдгийг цухас боловч дурдъя.

Уг бяцхан шүлгийн урьд өмнө хэвлэсэн монгол эхийн арав орчим мөр хийгээд Д.Ёндоны орчуулсан хэсгийн агуулга нь бүхэлдээ уламжлалт дорно дахины сургаалын жижиг жишээ мөн байна. Хэдий тийм боловч “багшийн иог мэт увдис үгүй” гэх мэт бурхан шашны ёсны чухал санаа бүхий хэд хэдэн мөр шад бэлхнээ нэмэгдэх нь дээр харгуулсан төвөд эхүүдээс илэрхий мэдэгдэм хийгээд мөн арав илүү шадар баяжих нь тодорхой харагдаж байна.


Дээрх монгол төвөд эхүүдээс ажиглахад хамгийн бүрэн бүтэн гэж болмоор эх нь Улсын номын сангийн төвөд бичмэл юм. Хэдий тийм боловч үүнд цэгцтэй хариулт өгөхөд эрдэмтэн Д.Ёндоны дурдаж өнгөрсөнчлөн монгол төвөд

хоёр хэлний чухам аль хэлээр түрүүлэн зохиосон тухай өгүүлэхэд бэрхшээлтэй гэдэг нь үнэн юм.



4. Дүгнэлт

Ийнхүү нэг шүлгийн монгол төвөд эх хэд хэд олдоод байгаа нь зохиогч уг шүлгийг анх ямар хэлээр зохион туурвисныг олж тогтооход чухал нөлөөтэй. Хэдий тийм боловч Ноён хутагтын зохиол бүтээлүүдэд энэ мэт ээдрээ төвөгтэй асуудал үүгээр тогтохгүй. Дээрх хэдэн эх бичгийн хувьд хамгийн бүрэн бүтэн гэж үзэж болмоор эх бичиг нь Улсын номын сангийн төвөд бичмэл эх болох тухай өмнө дурдсан, мөн эрдэмтэн Д.Ёндон төвөд хэлнээс орчуулсан болох нь тодорхой хэвлэл, өөр хоёр ч төвөд эхийн хуулбар олдсон зэргээс дүгнэж хэлэхэд энэхүү зохиолыг Ноён хутагт анх төвөд хэлээр туурвин зохиосон гэж болох юм. Гэвч Ноён хутагт Данзанравжаагийн хараахан ил болж амжаагүй зохиол бүтээлийн их өв сангийн дундаас ямархан судар сурвалж, эх бичгүүд илрэн гарахыг бид таамаглаж мэдэхийн аргагүй тул ийм дүгнэлт хийх нь эрт байж болохыг ч үгүйсгэхгүй гэдгийг цохон тэмдэглэх нь зүйтэй.


Эх бичгүүдийн зөрөөг сонирхон судлагч хүмүүст зориулж төвөд эхийн хувилбар бүрийн гэрэл зургийг хавсаргав.



Зураг 1. “Итгэмжлэх мэтийн итгэл үгүй” шүлгийн
Монгол Улсын Үндэсний номын санд буй эхийн гэрэл зураг



Зураг 2. “Тавдугаар ноён хутагтын төвөд хэлээр туурвисан зохиолын эмхэтгэл” дотор буй эхийн гэрэл зураг




Зураг 3. “Тавдугаар ноён хутагтын төвөд хэлээр туурвисан зохиолын эмхэтгэл” дотор буй эхийн гэрэл зураг

Ном зүй

Дамдинсүрэн, Ц. (1959). Монгол уран зохиолын дээж зуун билэг оршвой. Улаанбаатар. 445-р тал. (Damdinsuren, Ts. Mongol uran zokhiolyn deej zuun bileg orshvoi. (A hundred finest books of Mongolian literature, Zuun bileg.] Ulaanbaatar, 1959: 445.)

- Алтангэрэл, Ч.** (1968). *Монгол зохиолчдын төвөдөөр бичсэн бүтээл*. Улаанбаатар. 3-4; 121-122; 240-р тал. (Altangerel, Ch. *Mongol zohiolchdyn töwödөөр bichsen бүтээл* (Literary works in Tibetan language with Mongolian authors.] Ulaanbaatar, 1968: 3-4; 121-122; 240.]
- Ёндон, Д.** (1977). *Монголын уран зохиолын тойм*. II дэвтэр. Ред. Ц.Дамдинсүрэн, Д.Цэнд. Улаанбаатар, 590-р тал. (Yondon, D. *Mongolyn uran zokhiolyn тойм* (Review of Mongolian Literature] Volume II. Ulaanbaatar, 1977: 590.]
- Цагаан, Д.** (1962). *Д.Равжаа. Зохиолын эмхэтгэл*. Улаанбаатар, 323-р тал. (Tsagaan, D. *Zokhiolyn emkhetgel* (Compilation of works. Ulaanbaatar, 1962: 323.]
- Цагаан, Д.** (1992). *Д.Равжаа. Яруу найргийн цоморлиг*. Улаанбаатар, 182-р тал. (Tsagaan, D. *D.Ravjaa. Yaruu nairgiin tsomorlig* (Anthology of poetry. Ulaanbaatar, 1992: 182.]
- Отгонбаатар, Р.** (2019) *Равжаагийн монгол төвөд хэлээр бичсэн хошоод шүлгийн тухай*. - Төвөд судлал сэтгүүл. Боть 8. Дэвтэр 1-14. Улаанбаатар, 28-37-р тал. (Otgonbaatar, R. *About Ravjaa's two poems written in Mongolian Tibetan*] Tibetan studies. VIII. Fasc. 1-14. Ulaanbaatar, 2019: 28-37.]
- Мөнх-Отгон, Д.** (2022). *Ноён хутагтын хоёр хэлээр буй сургаалын шүлгээс*. - Төвөд судлал сэтгүүл. Боть 11. Улаанбаатар, 114-121-р тал. (*Munkh-Otgon. D, From the advice verses written in two different languages by Noyon Khutugtu*] Tibetan studies. XI. Ulaanbaatar, 2022: 114-121.]
- Тавдугаар ноён хутагтын төвөд хэлээр туурвисан зохиолын эмхэтгэл.* (2023) Эрхлэн хэвлүүлсэн Намогүрүлин номын төв, Гандантэгчэнлин хийдийн Эрдэм соёлын хүрээлэн.
- Алтан хүрдэн.** (1992). *Хэвлэлд бэлтгэсэн Л.Хүрэлбаатар*. Улаанбаатар, 20-р тал. (*Altan khurden. Edited by L.Khurelbaatar*] Golden wheel. Ulaanbaatar, 1992: 20.]



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.